

Салхинд намиран дэрвэх шар орхимж буюу Монгол дахь Бурхны шашны хөдөлгөгч хүч

Гвидо Вербуум, Шашныг Хамгаалах Нийгэмлэг

Юмс үзэгдэл тохиолдож л байдаг

Шашин бол хүний нийгмийн түүхэнд нийтлэг соёл хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн бодит бөгөөд өвөрмөц үзэгдэл юм. Өөрөөр хэлбэл, дэлхий дээрх бүх л соёл нь шашны элементийг агуулсан байдаг. Ерөнхийдөө, шашин нь хүний сүсэг бишрэл (оюун санаа) болон үйл ажиллагааны аль алинд нь тусгалаа олсон бөгөөд тэрээр ямар нэгэн хувирашгүй мөнхийн зүйл биш, харин түүхийн явцад байнга хувьсан өөрчлөгдөж байдаг үзэгдэл юм. Хэдийгээр шашныхаа хүрээнд түүнийг ихэвчлэн эртний сургаалиас үүдэлтэй гэж үздэг боловч шашин нь үргэлж өөрөө өөрийгөө тодорхойлж байдаг үргэлжлэх процесс юм. Энэ үүднээс бид Монгол дахь Буддын (Бурхны) шашны хөгжлийг авч үзэх болно.

Өнгөрсөн буюу юу болсон бэ?

Буддизм буюу Бурхны шашин нь эртний Энэтхэгт Хиндуизм гэдэг ерөнхий нэрээр хэрэглэгдэж байсан шашны урсгалуудаас гаралтай бөгөөд Бадманшамбхава буюу Гүр ринбүүчи түүнийг Төвдөд авчирчээ. Тэрээр Будда Шахъямунигийн “Зовлонгийн төгсгөл”-ийн сургаалыг уугуул нутгийнхны сүсэг бишрэлтэй холбож өгсөн юм. Өмнөх хэд хэдэн оролдлогын дараа буюу зөвхөн 16-р зуунд л түүнийг Монголд танилцуулж улмаар монголчуудын голлон шүтэх шашин болгож чадсан байна. Тэгэхдээ Бурхны шашныг Төвдөд авчирч дэлгэрүүлсэнтэй адилаар шинэ орчинд буюу Монголын нөхцөлд тохируулан хүмүүсийн оюун санаанд гүн шингээжээ. Хөгжиж цэцэглэж байсан хэдэн зууны дараа буюу 20-р зуун Монгол дахь бурхны шашны түүхэнд хар үе болж үлдсэн юм. Бурхны шашныг илээр шүтэх явдлыг хориглосноор хүмүүсийн сүслэн мөргөх нь нуугдмал байдалд шилжсэн юм.

Өнөө буюу одоо юу болж байна вэ?

1990 онд хүмүүсийн тахин шүтэх эрх чөлөө Монголд эргэж ирсэн бөгөөд настай лам нар ч орхимж жанчаа өмсөхийн зэрэгцээ бараг мартагдаад байсан мөргөлийн дуу зэргийг залуучуудад зааж сургаж эхэлсэн юм. Хүмүүс өөрсдийн гарал үүсэл, амьдралын мөн чанарыг хайж, түүнийгээ ч олох болж. Бараг устаад байсан сүм хийдүүд сэргэж, шинээр ч олныг барьж босгоод байна. Ингэж Бурхны шашны шинэ үе эхэлжээ.

Ирээдүй буюу цаашид яах бол?

Монгол дахь Бурхны шашин өөрийн хөгжлийн чухал үедээ ороод байна. Зарим хүмүүс шашин шүтлэгийг хуучинсаг хэв жаягийн цуглуулга гэж боддог бол зарим нь Бурхныг шүтсэнээр сүсэг бишрэлийн шинэ итгэл, сэтгэлийн амирлингуйг олох болжээ. Үүний хажуугаар бусад шашны урсгалууд ч олноор орж ирэх болсон юм. Тэгэхээр цаашид яах бол? Энэ асуудал дээр таны ч бодлыг бас сонсмоор байна.